



БАТЛАВ:  
СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА  
..... /З.ТҮВШИНТӨГС/

2024 оны 06 дүгээр сарын 27 өдөр

Сүхбаатар

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМЫН 3 ДУГААР БАГИЙН НУТАГ ЖАРГАЛАНТЫН  
БУЛГИЙН УСЫГ ХУРИМТЛУУЛЖ ЦӨӨРӨМ БАЙГУУЛАХ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ  
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, АЖЛЫН ДААЛГАВАР

1. Зураг төсөл, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх үндэслэл	- Аймгийн Засаг даргын Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай хамтран ажиллах гэрээ - Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр - Зураг төсвийг усны барилга байгууламжийн зураг төсвийн “Зөв хаус констракшн” ХХК-аар гүйцэтгүүлсэн.
2. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Аймгийн ИТХ-ын 142 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал” 223 470 000 төгрөг /хоёр зуун хорин гурван сая дөрвөн зуун далан мянга/
3. Захиалагч байгууллага	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
4. Байршил, зориулалт, хүчин чадал	Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Жаргалантын булаг нэртэй газарт гадаргын усыг хуримтлуулах, уур амьсгалыг тодорхой түвшинд зөөлрүүлэх, усан мандал бий болгох, , ус нөөцлөх зориулалт бүхий 10000 м <sup>3</sup> -ээс багагүй эзэлхүүнтэй, цэнгэг устай хиймэл нуур ( цөөрөм) хийж гүйцэтгэх;
5. Зураг төсөвт тавигдах шаардлагууд	Хөв, цөөрөм байгуулах газрын байршлыг тогтооходоо орон нутгийн төр захиргааны байгууллага, иргэд, малчдын санал хүсэлтийг харгалзан үзэх; хурлын протоклыг хөтлөж баталгаажуулах Үерийн их урсацыг 100 жилд нэг удаа тохиолдох магадлалтайгаар (2%-н хангамшилтайгаар), гачиг үеийн урсацыг 2 жилд нэг удаа тохиолдох магадлалтайгаар тооцоонд авах; Усны нөөцийг зүй зохистой, ариг гамтай ашиглах, байгаль орчинд сөрөг нөлөөгүй байхаар цөөрмийг төлөвлөх; Цөөрмийг барьж ашиглахад энгийн, найдвартай ажиллагаатай, өртөг зардлыг хэмнэсэн байх; Цөөрөм байгуулах боломжит газрын судалгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх
6. Зураг төсөв, барилгын ажлын зохион байгуулалт, түүнд тавигдах шаардлагууд	Гүйцэтгэгч зураг төсөв боловсруулах даалгаврыг үндэслэн, цөөрөм байгуулах ажлын зураг төслийг боловсруулах; Техник технологийн хувьд дэвшилтэт, эдийн засгийн хувьд хэмнэлттэй шийдэл тусгах; Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол Улсад мөрдөж буй хууль тогтоомж, БНБД стандартын дагуу хийж гүйцэтгэх; Барилгын ажлыг хийж гүйцэтгэхдээ гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу хугацаанд нь ашиглалтад өгөхөөр ажлын талбайн зохион байгуулалтыг хийх шаардлагатай. Захиалагч барилгын ажлыг гүйцэтгэж эхлэх үеэс нь эхлэн ажлыг хийж дуусгах хүртэлх бүх технологийн үйл ажиллагаанд хяналт тавина. Гүйцэтгэгчийн барилга угсралтын ажилд хэрэглэх бүх материал нь шинэ, өмнө нь ашиглагдаагүй байх;
7. Гүйцэтгэгч	1. Гүйцэтгэгч байгууллага нь ажлын даалгаврын дагуу ажлыг чанарын

<p><b>байгууллага</b></p>	<p>өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.</p> <p>2.Талбайд барилгын ажлын журналыг байнга хөтөлж, хяналтын инженерүүдийн өгсөн үүрэг даалгавар, шаардлага, дүгнэлтийн биелэлтийг гаргана.</p> <p>3.Барилга угсралтын ажилд ашиглах материалыг урьдчилан захиалагч, ашиглагч байгууллагад танилцуулж зөвшилцөнө.</p> <p>4.Улаан шугам тавьж ажлыг эхлэхээс өмнө мэргэжлийн байгууллагуудаас газар шорооны ажил эхлэх зөвшөөрлийг авсан байх, шаардлагатай бол биет төлөөлөгч байлцуулан гүйцэтгэнэ.</p> <p>5.Захиалагч, ашиглагч байгууллагын төлөөлөгчдийг байлцуулан үе шатны ажил тус бүрийг фото зургаар баталгаажуулан, акт үйлдэнэ.</p> <p>6.Гүйцэтгэгч гэрээний бусад баримт бичгүүдтэй сайтар танилцаж, зохих журмын дагуу ажил эхлүүлэх зөвшөөрлийг гэрээнд гарын үсэг зурснаас хойш 14 хоногийн дотор авсан байх;</p> <p>7.Ажил гүйцэтгэх явцад талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллана.</p> <p>8.Байгалийн гэнэтийн гамшиг, гал түймэр, үер усны гамшигаас сэргийлэн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах ба хэрэв ямар нэг арга хэмжээ авалгүй гэнэтийн гамшигт өртвөл гүйцэтгэгч хариуцна.</p> <p>9.Гүйцэтгэгч нь хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны нөхцлийг бүрэн хангаж, үүнээс гарах хор хохирлыг өөрсдөө хариуцна.</p> <p>10. Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь импортын материал ашиглах нөхцөлд гарал үүсэл, тохирлын гэрчилгээ, сертификат, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргасан байх;</p> <p>11. Аль болох үндэсний үйлдвэрийн материалыг ашиглах ба ингэхдээ “Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ” лабораторийн шинжилгээний дүн хавсаргаж ирүүлнэ. Чанаргүй хийсэн ажлыг өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.</p> <p>12. Гэрээт ажлыг графикт хугацаанд бүрэн гүйцэтгэн ажил хүлээлцэх комиссоор байнгын ашиглалтанд хүлээлгэн өгнө.</p> <p>Жич: Дээрх техникийн тодорхойлолтонд заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч нар эрхийнхээ дагуу ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.</p>
<p><b>8. Ажлын даалгавар</b></p>	<p>1. Гүйцэтгэгч өгөгдсөн ажлын даалгаврыг газар дээр нь шалган үзэж, дутуу буюу орхигдсон ажлын даалгаврыг технологийн шаардлагын дагуу нэмж оруулж үнэлэн саналаа ирүүлнэ.</p> <p>2. Ажлын даалгаварт арифметик алдаа илэрсэн тохиолдолд тайлбарыг оролцуулан ажлын даалгаврыг засаж, үнэлж ирүүлнэ.</p> <p>3. Тендерт өгөгдсөн ажлын даалгавар төсөвт заавал тооцох, хасаж үнэлэх, зардлууд дутуу тооцсон байж болохгүй.</p> <p>4. Зураг төсвийн үнийг ажлын нийт төсөвт заавал тусгаж ирүүлнэ.</p> <p>5. Магадлашгүй ажлын тоо хэмжээ, зардлыг захиалагчийн зөвшөөрөл хяналтаар баталгаажуулна.</p> <p>6. Төсвийг тооцохдоо барилгын төсвийн Е5Т1МАТОК- РКО болон барилгын төсвийн зөвшөөрөгдсөн программаар боловсруулах, ажил гүйцэтгэх технологийн дагуу ажилбаруудыг зөв задалж үнэлэх; /Ажилбаруудыг дахин давтан үнэлсэн байж болохгүй/. Талбайгаас гарсан хог хаягдлыг зөвшөөрөгдсөн хогийн цэгт тээвэрлэх зардлыг тооцож ирүүлэх;</p> <p>7. Төсвийг мэргэжлийн төсөвчнөөр хийлгэсэн байх ба хуудас бүрийг баталгаажуулж, тамга тэмдэг дарсан байна.</p> <p>Төсвийг тооцохдоо Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 181 дүгээр тушаалын 1, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм”, /БНБД 81-94-12/, “Барилгын төсөв зохиох дүрэм” /БНБД 81-95-12/-ийг баримтална.</p>
<p><b>9.Захиалагчийн хяналт</b></p>	<p>• Барилга байгууламжийн ажлын зураг төсөв боловсруулах, угсралтын ажлыг гүйцэтгэж эхлэхээс дуусах хүртэлх бүх технологийн</p>

	<p>үйл ажиллагаанд хяналт тавих;</p> <ul style="list-style-type: none"> <li>• Материалын чанарт хяналт тавих;</li> <li>• Угсралтын ажлын явцад гарах зураг төсөвтэй холбоотой асуудлыг холбогдох хүмүүстэй хамтарч шийдвэрлүүлэх;</li> </ul> <p>Магадлашгүй ажлын зардалд зориулсан мөнгөн дүнг төслийн менежерийн шийдвэрийн дагуу захиалагч, гүйцэтгэгч, ашиглагчийн төлөөлөгчид оролцсон комисс акт тогтоон, төсөв тооцоо хийж /шаардлагатай бол зураг хийх/ баталгаажуулан санхүүжүүлэх;</p>
<b>10. Онцгой нөхцөл</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хүн, мал осолдохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх;</li> <li>• Хиймэл нуурын эргийг чулуун бэхэлгээгээр төлөвлөх;</li> <li>• Газар хөдлөлтийн эрсдэлийг тооцох;</li> </ul> <p>Хөв цөөрмийн орчимд гоц халдварт өвчинтэй сэг, зэм булшилсан эсэхийг сайтар нягтлах;</p>
<b>11. Ажлыг гүйцэтгэхэд дагаж мөрдөх барилгын норм, дүрмүүд</b>	<p>БД 81 -16-12 Зураг төслийн ажлын жишиг үнэ  БД 81-106-11 Усны барилга байгууламжийн зураг төслийн ажлын жишиг норм  ЗГ-ын 2009 оны 204 дүгээр тогтоол, Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм ЗГ-ын 2012 оны 151 дүгээр тогтоол, Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм БНБД 33-01-03 Усны барилга, байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам  БНБД 81-33-10 Усны барилга байгууламжийн ажлын төсвийн суурь норм  БНБД 81-95-12 Барилгын төсөв зохиох дүрэм  БНБД 11-06-03 Зургийн ерөнхий инженер (ерөнхий архитектор) -ийн дүрэм  БНБД 11-07-04 Барилга, байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл  БНБД 11-03-01 Барилгын инженер геологийн ажил  БД 81-105-11 Усны барилга байгууламжийн инженер, хайгуул судалгааны ажлын жишиг норм  БНБД 12-01-09 Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт  БД 12-101-05 Барилга угсралтын ажилд мөрдөх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар  БНБД 11-08-06 Барилгын геодезийн ажил  БНБД 3.01.06-90 Барилгын орчны тохижилтын ажил  БНБД 3.02.01-90 Барилгын газар шороо ба буурь, суурийн ажил  БНБД 33-03-05 Голын гидротехникийн барилга байгууламж  БНБД 33-04-09 Усны барилга байгууламжийн буурь  БНБД 33-05-09 Усны барилга байгууламжийн ачаалал ба үйлчлэл  БНБД 33-06-09 Усны барилга байгууламжийн бетон ба төмөр бетон бүтээц</p>
<b>12. Нэмэлт тайлбар</b>	<p>ШУА-ын Газарзүй Гео-Экологийн хүрээлэнгийн Усны салбарын хийж гүйцэтгэсэн хөв цөөрөм байгуулах боломжит газрын судалгаан дээр үндэслэсэн болно.</p>

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:  Г.ХОНГОР

БОАЖГ-ЫН УСНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН